



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ



Стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах

Төрийн албаны
тухай хуулийн
53.1.
2017.12.07

- Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн **харьяа байгууллагын** дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

Засгийн газар,
Засгийн газрын
Хэрэг эрхлэх
газар

Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах,
хэрэгжилтийг хангах журам. Засгийн газрын
2020.12.16-ны 216 дугаар тогтоол
Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал. ЗГХЭГ-
ын даргын 2020 оны 100 дугаар тушаал



Өмнөх эрх зүйн орчин

- **Төрийн албаны тухай** 2002 оны хуульд энэ тухай зохицуулалт байгаагүй.
- 2002 онд батлагдсан **Төсвийн байгууллагын** удирдлага, санхүүжилтийн тухай хууль.
/2011 онд Төсвийн тухай шинэ хууль батлагдсантай холбогдон хүчингүй болсон/
- **ТБУСТ хуулийн 26 дугаар зүйл. Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө**

26.1. Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь тухайн байгууллагын төсөв боловсруулах үндэслэл болно.

26.2. Төлөвлөгөөнд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараахь зүйлийг тусгана:

26.2.1. байгууллагын 3 жилийн хэтийн зорилтууд;

26.2.2. дараагийн жилд нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, өртөг;

26.2.3. жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй ижил үзүүлэлтээр боловсруулсан байгууллагын төсөв;

26.2.4. өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад асуудал.



Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 93 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭТИЙН (БИЗНЕС) ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

I. ОРШИЛ

1. Зааврын зорилго

Улсын салбарын өнөөгийн тогтолцоог шинэчлэх хууль эрх зүйн үндэс болсон “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай Монгол Улсын хууль”-ийг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү “Үйл ажиллагааны хэтийн (бизнес) төлөвлөгөө боловсруулах заавар”-ыг боловсруулав. Энэхүү заавар нь төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн (бизнес) төлөвлөгөө боловсруулахад тус дэм болох зорилготой.

II. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Бизнесийн стратеги төлөвлөлт нь эрхэм зорилго[5] тодорхойлох, орчны шинжилгээ[6] хийх, стратегиуд[7], зорилтыг тодорхойлох, санхүүгийн төлөвлөгөө[8] боловсруулах, шаардагдах нөөц, үйл ажиллагааг төлөвлөх болон үнэлгээ хийх зэрэг дэс дараа бүхий үе шатуудаас бүрдэх байнгын үйл ажиллагаа юм.

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Засгийн газрын үйл
ажиллагааны хөтөлбөр


Засаг даргын үйл
ажиллагааны хөтөлбөр

Хөгжлийн зорилтот
хөтөлбөр

Монгол Улсыг
хөгжүүлэх 5 жилийн
үндсэн чиглэл

Аймаг, нийслэл, хотыг
хөгжүүлэх 5 жилийн үндсэн
чиглэл

Алсын хараа-2050



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН
ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ



Стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Салбарын стратеги төлөвлөгөө

- Салбарын болон салбар дундын хамтран хэрэгжүүлэх зорилтуудыг хамруулан стратеги боловсруулах

2. Нутаг дэвсгэрийн стратеги төлөвлөгөө

- Засаглалын түвшин хоорондын болон хэд хэдэн салбарын хамтран хэрэгжүүлэх зорилтуудыг хамруулан стратеги төлөвлөгөө боловсруулах



Стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгууллагын стратеги төлөвлөгөө:
 - яамны харъяа агентлаг нь **салбарын сайдаар**,
 - аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг нь **аймаг, нийслэлийн Засаг даргаар** тус тус батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна.
- Байгууллагын стратеги төлөвлөгөөг **салбарын болон нутаг дэвсгэрийн стратеги төлөвлөгөөтэй нягт уялдуулан боловсруулна.**



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Бодлогын баримт бичигт тусгагдсан болон **хуулиар ногдуулсан чиг үүргийг** хэрэгжүүлэх зорилтуудыг **хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлох** нь стратеги төлөвлөгөөний **суурь** болно.
- Тухайн **салбар** болон **нутаг дэвсгэрийн нэгжид** хуулиар ногдуулсан **чиг үүргийг** хэрэгжүүлэх зорилго зорилтыг **салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага өөрсдөө** тодорхойлно.



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДСЭН БҮТЭЦ */нэмэлт, өөрчлөлтийн санал/*

1. Мандатын шинжилгээ

2. Алсын хараа, эрхэм зорилго

3. Дотоод, гадаад орчны шинжилгээ

Салбарын болон нутаг дэвсгэрийн стратеги төлөвлөгөө хийх шатанд бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтод свот шинжилгээ хийнэ.

4. Стратегийн зорилтыг тодорхойлох

5. Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6. Стратеги төлөвлөгөөний хавсралт

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах



Салбарын болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр зохион байгуулна.

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг зохион байгуулна.

Байгууллагын удирдлага стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц (хүн, санхүү, техник)-ийг бэлтгэж зохион байгуулна.

Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлж, стратегийн үр дүнг тооцох

**Стратеги
төлөвлөгөөний
гүйцэтгэл, үр
дүнг тооцох**

Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл нь тухайн салбарын болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид харъяалагдах байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгээр үнэлэгдэнэ.

Үнэлгээнд үндэслэн тухайн жилийн зорилтот түвшинд хүрч чадаагүй үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, алдаа дутагдлыг арилгах арга хэмжээг төлөвлөн дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгана.

Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авна.



4.1. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		
үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	
Ерөнхий чиг үүрэг-1:		
Үндсэн чиг үүрэг		Дэд чиг үүрэг
ҮЧҮ-1:		Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-2:		
ҮЧҮ-3:		
Ерөнхий чиг үүрэг-2:		ГЭХ МЭТ

Алсын хараа**Эрхэм зорилго****АЛСЫН ХАРАА**

- ❖ Салбарын / Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн урт хугацааны буюу хэтийн төлөв
- ❖ Салбарын / орон нутгийн хөгжлийг хаана хүрэхийг хүсч байгааг илэрхийлнэ.

Тавигдах шаардлага: Товч, тогтооход хялбар, уриалсан, өдөөсөн, төгс байдлыг дүрсэлсэн байх

ЭРХЭМ ЗОРИЛГО / Салбарын хувьд /

Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх одоо ба ирээдүйн үйл ажиллагааны талаарх хүсэл эрмэлзэл, үнэт зүйл, хөгжлийн үзэл баримтлал, оршин тогтнох учир шалтгааныг илэрхийлнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО / Орон нутгийн хувьд /

Орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, орон нутгийн хөгжлийг хангах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх одоо ба ирээдүйн үйл ажиллагааны талаарх хүсэл эрмэлзэл, үнэт зүйл, хөгжлийн үзэл баримтлал, оршин тогтнох учир шалтгааныг илэрхийлнэ.

ДОТООД, ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ */нэмэлт, өөрчлөлтийн санал/*

6.1. Дотоод орчны шинжилгээг дараахь хүрээг хамруулан хийнэ:

- Зорилго
- Бүтэц, зохион байгуулалт
- Нөөц
- Соёл
- Технологийн үйл явц

6.2. Дотоод орчны хүрээнд хийсэн шинжилгээний үр дүнгээр стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд нутгийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, нөөцийг төлөвлөх, хэрхэн оновчтой зохицуулах, нутгийн удирдлагын тогтсон соёл, үйл ажиллагааны технологийн үйл явцыг хэрхэн сайжруулах арга замыг тодорхойлно.



6.3. Гадаад орчны шинжилгээг дараахь хүрээг хамруулан хийнэ:

- Эрх зүй
- Улс төр
- Эдийн засаг
- Нийгэм, соёл
- Технологи
- Байгаль орчин

6.4. Гадаад орчны хүрээнд хийсэн шинжилгээний үр дүнгээр эерэг болон сөрөг нөлөөлөл, түүнийг даван туулах арга замыг тодорхойлно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

Төлөвлөгөө баталсан:
Аймгийн Засаг дарга

Төсвийн Ерөнхийлөн захирагч
.....

..... АЙМГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт		Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр /сая төгрөг	Хэрэгжүүлэгч болон хамтрагч байгууллага
	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт	Хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт						
ЕЧҮ-1: Байгалийн баялаг, байгаль орчин, аялал жуулчлал								
ҮЧҮ-1. Ашигт малтмалын хайгуул хийх, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлэх								
1.								
	1.1		-					
	1.2		-					
	1.3		-					
ҮЧҮ-2. Байгаль хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх								



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ЖИШЭЭ

Бодлого тодорхойлох:

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

Зорилт	Арга хэмжээ
3.3.1. сумын нутагт орших шохойн чулууны ордыг түшиглэн жилд 360 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг байгуулж, төмрийн хүдрийн ордыг түшиглэн төмрийн <u>хүдэр баяжуулах, экспортлох төслийг</u> хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.	1. сумын нутагт орших шохойн чулууны ордыг түшиглэн жилд 360 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулна. 2. сумын нутагт орших төмрийн хүдрийн ордыг түшиглэн төмрийн хүдэр баяжуулах, экспортлох төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар эхлүүлнэ.
4.3. Орон нутагт хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, <u>экспортыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хэмжил зүй, стандартчилал, сорьцын хяналт, тохирлын үнэлгээний бодлого, үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлж, чанартай төрийн үйлчилгээг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөд тулгуурлан хэрэглэгчдэдээ хүргэнэ.</u>	4.3.1. аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүд, хэрэглэгчдийн шаардлагыг хангаж Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2016 стандартыг нэвтрүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлж 2021-2024 онд 5-аас доошгүй байгууллагад дээрх стандартыг нэвтрүүлнэ. 4.3.2. орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын үнэн зөв байдлыг хангана. 4.3.3. аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар “Стандарттай” дэд хөтөлбөр батлуулж, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Зорилт	Арга хэмжээ
1.1.2. Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад чиглэсэн дэмжлэг, туслалцааг нэмэгдүүлнэ.	Цар тахлын үеийн болон дараах аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх төслийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, малчдад санхүүгийн дэмжлэг олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана.
4.4.1. Гамшгийн бэлэн байдлын бодлого, төлөвлөлтийг шинэчлэн, гамшгаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хор уршгийг шуурхай арилгах менежментийг хэрэгжүүлнэ.	8 сумд гамшгаас хамгаалах иж бүрэн, 12 сумд гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг тус тус зохион байгуулна.



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Анхаарал хандуулсанд баярлалаа